



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБАНЫ 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/152/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С. Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэчимэг
Утас: 261628 Цахим хаяг: erdenechimegch@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: Ол Дөш Хайрхан Аудит ХХК
Захирал: А.Саранцэцэг
Утас: 99250679 Цахим хаяг: avirmedsaraa@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

| | |
|-----------------------------------------------------------------------------------|----|
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 3 |
| 3. Аудитын тайлан | 13 |
| 3.1 Ерөнхий зүйл | 13 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хянал | 13 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 14 |
| 3.4 Материаллаг байдал | 14 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 14 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 15 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 17 |
| 3.8 Аудитын гол асуудал | 17 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 17 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 17 |
| 4. Аудитын илрүүлэлт | 19 |
| 4.1 Залруулсан алдаа | 19 |
| 4.2 Зөвлөмж | 19 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-------------------------------------------------------------|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АХГ | Аудитын хоёрдугаар газар |
| ОУАЭА | Олон улсын атомын энергийн агентлаг |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ЦШНИ | Цөмийн шинжилгээний нэгдсэн институт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07 407
танай _____ -ны № _____ -т

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Г. МАНЛАЙЖАВ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2022\0225 Auditin 2 Gazar - 64.Docx

001050454

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|----------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 184,360,755.08 | 104,758,316.70 |
| 33 | АВЛАГА | 35,255,000.00 | 18,955,737.79 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 30,737.79 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 35,255,000.00 | 18,925,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 149,105,755.08 | 85,802,578.91 |
| 351 | Түүхий эд материал | 45,910,418.19 | 9,767,989.26 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 45,910,418.19 | 9,767,989.26 |
| 354 | Хангамжийн материал | 103,195,336.89 | 76,034,589.65 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 8,985,351.00 | 3,081,098.50 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,148,164.00 | 2,312,873.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,444,862.95 | 5,490,912.95 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 77,616,958.94 | 65,149,705.20 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,919,634,359.74 | 3,916,750,509.89 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,919,634,359.74 | 3,916,750,509.89 |
| 392 | Биет хөрөнгө | 2,816,235,171.64 | 2,814,559,127.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,100,543,041.38 | 2,100,543,041.38 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (172,694,436.72) | (259,041,655.08) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 155,828,000.00 | 155,828,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (153,228,000.04) | (155,828,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,536,012,817.24 | 1,768,838,790.22 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (655,857,595.54) | (801,035,621.77) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 86,284,253.60 | 86,284,253.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (86,032,353.34) | (86,123,953.30) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 108,375,085.60 | 108,375,085.60 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (102,995,640.54) | (103,280,813.34) |
| 393 | Биет бус хөрөнгө | 1,103,399,188.10 | 1,102,191,382.58 |
| 39301 | Программ хангамж | 25,759,027.60 | 25,759,027.60 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (22,236,261.50) | (23,444,067.02) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,099,876,422.00 | 1,099,876,422.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 4,103,995,114.82 | 4,021,508,826.59 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,103,995,114.82 | 4,021,508,826.59 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,103,995,114.82 | 4,021,508,826.59 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГС/ | 1,099,876,422.00 | 1,099,876,422.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,099,876,422.00 | 1,099,876,422.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,366,957,876.27 | 1,284,471,588.04 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,366,957,876.27 | 1,366,957,876.27 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | (82,486,288.23) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,637,160,816.55 | 1,637,160,816.55 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,103,995,114.82 | 4,021,508,826.59 |

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|-----------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,363,701,262.00 | 1,515,097,623.24 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 91,344,662.00 | 224,131,423.24 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 91,344,662.00 | 224,131,423.24 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 91,344,662.00 | 224,131,423.24 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 32,280,800.00 | 27,474,380.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 59,063,862.00 | 196,657,043.24 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,272,356,600.00 | 1,290,966,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,272,356,600.00 | 1,290,966,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,272,356,600.00 | 1,290,966,200.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,544,279,489.04 | 1,597,583,911.47 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,544,279,489.04 | 1,597,583,911.47 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 933,595,928.07 | 1,043,847,782.89 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 445,793,111.60 | 442,575,157.50 |
| 210101 | Үндсэн цалин | 325,727,598.12 | 325,806,581.97 |
| 210102 | Нэмэгдэл | 93,941,563.48 | 83,408,575.53 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,123,950.00 | 33,360,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 59,857,545.92 | 59,534,294.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,706,501.88 | 41,895,325.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,877,410.24 | 4,608,435.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,888,773.08 | 3,538,908.88 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 762,332.89 | 852,935.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,622,527.83 | 8,638,689.75 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 49,652,993.13 | 37,893,794.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,316,492.00 | 15,169,080.52 |
| 210302 | Түлш, халаалт | 9,265,440.98 | 8,911,837.47 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,467,060.15 | 1,212,077.00 |
| 210304 | Байрны түрээс | 12,604,000.00 | 12,600,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 55,454,493.79 | 114,402,589.85 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,802,440.00 | 8,844,337.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,233,520.00 | 8,270,850.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,877,691.45 | 9,390,186.42 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,944,800.00 | 1,614,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,609,834.00 | 4,038,547.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 23,986,208.34 | 82,244,468.93 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,890,537.00 | 15,111,910.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 470,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 9,420,537.00 | 15,111,910.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 24,600.00 | 927,795.00 |

Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------|-------------------------|------------------------|
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 24,600.00 | 927,795.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 80,502,788.00 | 136,238,918.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 64,253,700.00 | 126,179,118.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,142,776.00 | 3,055,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 20,800.00 | 401,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 100,200.00 | 100,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,336,700.00 | 2,852,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 7,202,852.00 | 128,100.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,445,760.00 | 3,522,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 232,419,858.63 | 237,163,322.83 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,453,500.00 | 1,453,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 230,966,358.63 | 235,709,822.83 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 610,683,560.97 | 553,736,128.58 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 478,466,648.00 | 478,466,253.41 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 478,466,648.00 | 478,466,253.41 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 22,607,500.00 | 5,373,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,928,800.00 | 5,373,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,678,700.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 109,609,412.97 | 69,896,875.17 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 109,609,412.97 | 69,896,875.17 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (180,578,227.04) | (82,486,288.23) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (180,578,227.04) | (82,486,288.23) |

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|-----------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,319,222,400.00 | 1,334,770,580.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 46,865,800.00 | 43,804,380.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 46,865,800.00 | 43,804,380.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 46,865,800.00 | 43,804,380.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 46,865,800.00 | 43,804,380.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,272,356,600.00 | 1,290,966,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,272,356,600.00 | 1,290,966,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,272,356,600.00 | 1,290,966,200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,319,222,400.00 | 1,270,641,780.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,319,222,400.00 | 1,270,641,780.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 708,538,839.03 | 716,905,651.42 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 447,262,475.53 | 442,721,006.99 |
| 210101 | Үндсэн цалин | 320,887,254.05 | 325,952,451.80 |
| 210102 | Нэмэгдэл | 100,210,221.48 | 83,408,587.45 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,165,000.00 | 33,359,967.74 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 59,857,545.92 | 58,641,941.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,706,501.53 | 41,006,965.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,877,410.24 | 4,506,923.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,888,773.15 | 3,541,558.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 762,332.89 | 871,081.27 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,622,528.11 | 8,715,412.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 49,652,993.13 | 37,893,794.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,316,492.00 | 15,169,080.52 |
| 210302 | Түлш, халаалт | 9,265,440.98 | 8,911,837.47 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,467,060.15 | 1,212,077.00 |
| 210304 | Байрны түрээс | 12,604,000.00 | 12,600,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 34,421,099.45 | 26,655,272.42 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,526,490.00 | 4,637,185.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,358,900.00 | 5,316,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,877,691.45 | 9,390,186.42 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,944,800.00 | 1,614,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,165,200.00 | 2,681,516.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,548,018.00 | 3,015,285.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 30,500,037.00 | 11,948,376.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,180,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 13,320,037.00 | 11,948,376.00 |
| 2107 | Томилот, зочны зардал | 00.00 | 701,100.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 701,100.00 |

Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------------|-----------------------|------------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 85,391,188.00 | 136,890,660.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 64,253,700.00 | 126,606,360.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,142,776.00 | 3,055,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 20,800.00 | 401,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 100,200.00 | 100,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,225,100.00 | 3,076,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 7,202,852.00 | 128,100.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,445,760.00 | 3,522,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,453,500.00 | 1,453,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,453,500.00 | 1,453,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 610,683,560.97 | 553,736,128.58 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 478,466,648.00 | 478,466,253.41 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 478,466,648.00 | 478,466,253.41 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 22,607,500.00 | 5,373,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,928,800.00 | 5,373,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,678,700.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 109,609,412.97 | 69,896,875.17 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 109,609,412.97 | 69,896,875.17 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 64,128,800.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 00.00 | 64,128,800.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 00.00 | 64,128,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 64,128,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 64,128,800.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 00.00 | (64,128,800.00) |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|----------------------------------------------|---------------------------------|-------------------------|-------------------------|----------------------------------------|
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,099,876,422.00 | 1,637,160,816.55 | 1,547,536,103.31 | 4,284,573,341.86 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,099,876,422.00 | 1,637,160,816.55 | 1,547,536,103.31 | 4,284,573,341.86 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | (180,578,227.04) | (180,578,227.04) |
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,099,876,422.00 | 1,637,160,816.55 | 1,366,957,876.27 | 4,103,995,114.82 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,099,876,422.00 | 1,637,160,816.55 | 1,366,957,876.27 | 4,103,995,114.82 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | (82,486,288.23) | (82,486,288.23) |
| 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,099,876,422.00 | 1,637,160,816.55 | 1,284,471,588.04 | 4,021,508,826.59 |

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|--------|----------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|----------------------|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,315,700,600.00 | 1,264,873,704.83 | 50,826,895.17 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,315,700,600.00 | 1,264,873,704.83 | 50,826,895.17 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 807,124,900.00 | 781,034,451.42 | 26,090,448.58 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 447,506,300.00 | 442,721,006.99 | 4,785,293.01 |
| 210101 | Үндсэн цалин | 323,446,300.00 | 325,952,451.80 | (2,506,151.80) |
| 210102 | Нэмэгдэл | 92,506,300.00 | 83,408,587.45 | 9,097,712.55 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 31,553,700.00 | 33,359,967.74 | (1,806,267.7) |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,413,400.00 | 58,641,941.02 | 1,771,458.98 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,513,100.00 | 41,006,965.15 | 1,506,134.85 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,475,100.00 | 4,506,923.31 | -31,823.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,580,100.00 | 3,541,558.57 | 38,541.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 895,000.00 | 871,081.27 | 23,918.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,950,100.00 | 8,715,412.72 | 234,687.28 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 43,578,000.00 | 37,893,794.99 | 5,684,205.01 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,690,400.00 | 15,169,080.52 | 2,521,319.48 |
| 210302 | Түлш, халаалт | 11,317,600.00 | 8,911,837.47 | 2,405,762.53 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,966,000.00 | 1,212,077.00 | 753,923.00 |
| 210304 | Байрны түрээс | 12,604,000.00 | 12,600,800.00 | 3,200.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 29,917,500.00 | 26,655,272.42 | 3,262,227.58 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,547,600.00 | 4,637,185.00 | 910,415.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,316,900.00 | 5,316,900.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,655,800.00 | 9,390,186.42 | 2,265,613.58 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,685,500.00 | 1,614,200.00 | 71,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,690,400.00 | 2,681,516.00 | 8,884.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,021,300.00 | 3,015,285.00 | 6,015.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 71,783,600.00 | 71,769,176.00 | 14,424.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 59,833,500.00 | 59,820,800.00 | 12,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 11,950,100.00 | 11,948,376.00 | 1,724.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 701,100.00 | 701,100.00 | 00.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 701,100.00 | 701,100.00 | 00.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 151,771,500.00 | 141,198,660.00 | 10,572,840.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 129,599,100.00 | 126,606,360.00 | 2,992,740.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,055,700.00 | 3,055,700.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 401,800.00 | 401,200.00 | 600.00 |

Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | |
|---------------|-----------------------------------------------------|-----------------------|-----------------------|----------------------|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 100,200.00 | 100,200.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,385,000.00 | 7,384,500.00 | 500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 7,707,100.00 | 128,100.00 | 7,579,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 3,522,600.00 | 3,522,600.00 | 00.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,453,500.00 | 1,453,500.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,453,500.00 | 1,453,500.00 | 00.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 508,575,700.00 | 483,839,253.41 | 24,736,446.59 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 478,468,300.00 | 478,466,253.41 | 2,046.59 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 478,468,300.00 | 478,466,253.41 | 2,046.59 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 30,107,400.00 | 5,373,000.00 | 24,734,400.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,373,000.00 | 5,373,000.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 24,734,400.00 | 00.00 | 24,734,400.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 00.00 | 1,264,873,704.83 | 1,264,873,704.83 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 00.00 | 1,221,069,324.83 | 1,221,069,324.83 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 00.00 | 1,221,069,324.83 | 1,221,069,324.83 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 00.00 | 43,804,380.00 | (43,804,380.00) |
| 120004 1 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 43,804,380.00 | (43,804,380.00) |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 00.00 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 33 | 33 | 00.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 4 | 4 | 00.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 29 | 29 | 00.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгийг зөв ангилан бүртгэж тайлагнах, хэрэгцээнээс илүү бараа материал нөөцлөхгүй байх, санхүүгийн программ хангамжийг сайжруулах зэрэг асуудлуудтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 18-ны хооронд Ол дөш хайрхан аудит ХХК-ийн аудитор Ц.Бумцэнд, аудиторын туслах Г.Билгүүн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Сарантуяа, захирал А.Саранцэцэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 1/62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цөмийн энергийн комиссын Ажлын алба нь эрхэм зорилгоо “Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийг бэлтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Улсын Их хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахаас гадна холбогдох хууль, журмын биелэлтийг хангах зорилтуудын хүрээнд Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого, Цөмийн энергийн тухай хууль, цөмийн идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагаа явуулдаг, Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталж, тус хуулийн дагалдах хуулиар Цөмийн энергийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Ерөнхий сайд” гэснийг “шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчилсөн. Тухайн өөрчлөлт нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин

төгөлдөр болж, Боловсрол шинжлэх ухааны сайд мөн өдрөөс Цөмийн энергийн комиссын даргаар ажиллахаар шийдвэр гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагад хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод хяналтыг хэрэгжүүлдэг тусдаа нэгжгүй, байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг байгууллагын удирдлага, төв төрийн сангаас хэрэгжүүлж байна.

Дотоод аудитаас өгсөн зөвлөмж, зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлангаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн байдлаарх нийт хөрөнгийн 4,103,995.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 41,039.9 мянган төгрөг, материаллаг байдлыг 65 хувь буюу 26,675.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,486.3 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---------------------------------------------------|--------------------|--------------------|-------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 35,255.0 | 18,955.7 | 16,299.3 |
| Бараа материал | 149,105.8 | 85,802.6 | 63,303.2 |
| Үндсэн хөрөнгө | 3,919,634.3 | 3,916,750.5 | 2,883.8 |
| Нийт хөрөнгө | 4,103,995.1 | 4,021,508.8 | (82,486.3) |
| Засгийн газрын оруулсан капитал | 4,103,995.1 | 4,021,508.8 | (82,486.3) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 4,103,995.1 | 4,021,508.8 | (82,486.3) |

Авлага дансны үлдэгдэл 18,955.7 мянган төгрөг болж, 16,299.3 мянган төгрөгөөр буурсан нь харилцагчдаас авах 16,330.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 85,802.5 мянган төгрөг болж, 63,303.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд Ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэх бодлого чиглэлийг хэрэгжүүлж ажилласантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,021,508.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 82,486.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Цөмийн энергийн комиссын Ажлын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 151,396.4 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 137,593.1 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлого 132,786.7 мянга, урсгал үйл ажиллагааны орлого 18,609.6 мянган төгрөгийн орлого байна.

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 18,609.6 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 366 дугаар тогтоолын дагуу Ажлын албаны төрийн захиргааны албан хаагчдын цалингийн шатлал нэмэгдсэнтэй холбоотой.

Үндсэн үйл ажиллагааны орлого 4,806.4 мянган төгрөгөөр буурсан нь 2020 онд Ковид-19 цар тахлын улмаас бэлэн байдлыг зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор үйл ажиллагаа хязгаарлагдмал байсан нөлөөлсөн байна.

Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 196,657.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гадаадын хандив тусламжаар авсан тоног төхөөрөмж, буруу ангилан бүртгэсэн биет хөрөнгийг залруулж бүртгэсэнтэй холбоотой.

Нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад 53,304.4 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бусад бараа үйлчилгээний зардал 53,313.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 55,736.1 мянган төгрөгөөр тус тус өссөн нь өмнөх онд Ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэх бодлого чиглэлийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг 9,367,332.7 мянган төгрөгөөр үүнээс бараа, үйлчилгээний болон бусад зардлыг 6,678,692.0 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 2,688,640.7 мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Цөмийн энергийн комиссын Ажлын алба нь сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалт болон төсөл арга хэмжээ хэрэгжүүлээгүй, ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмж хуучирч муудсан, тусгай зориулалтын тоног төхөөрөмжүүдийг бэлтгэх шаардлага гарч байгааг харгалзан урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг нэмж батлуулахаар төсвийг нэмэгдүүлэх санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 8,015,683.8 мянган төгрөгөөр бууруулж, 1,351,648.9 мянган төгрөгөөр баталсан байна. Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай“ 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн дагуу төсвийн тодотгол хийж, 35,948.3 мянган төгрөгөөр бууруулан баталсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд 11 стратегийн зорилт болон 24 дэд зорилтын хүрээнд нийт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,315,700.6 мянган төгрөгийн зардлын төсөв батлагдсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,221,069.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны 43,804.3 мянган төгрөгийн өөрийн орлогоор эх үүсвэр бүрдэж, үүнээс үйл ажиллагаанд 1,264,873.7 мянган төгрөгийг зарцуулж, 69,896.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,264,873.7 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,684.2 мянга, хангамжийн материалын зардал 3,262.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 10,572.8 мянга, урсгал шилжүүлгийн зардал 24,736.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсан, Ковид-19 цар тахал өвчний улмаас тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүй, мөн хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг 7,352.6 мянган төгрөгөөр бууруулан санхүүжүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэж ажиллах бодлого чиглэлийг баримтлан ажилласан зэрэгтэй холбоотой .

Хүснэгт- 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|------------|-----------|---------|---------|
| | Код | Нэр | | | | |
| 1 | | “Цацраг идэвхт ашигт малтмалын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх бодлогын судалгаа” төсөл | 73,526.1 | 66,173.5 | 7,352.6 | 90 хувь |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 24 хөтөлбөр, 48 арга хэмжээний хэрэгжилт 96.1 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90 хувийн биелэлттэй байна.

2021 оны эцсээр Цөмийн энергийн комиссын Ажлын алба Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага байсан нь өөрчлөгдөж Боловсрол, шинжлэх ухааны яамны бүтэцэд орсон.

Мөн 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд, Зөөвч-Овоо, Дулаан-Уул ордыг ашиглах төсөлд үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах, цөмийн энергийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх зэрэг ажлууд хийгдсэн байна.

Тус ажлын албаны чиг үүргийн хүрээнд Цөмийн энергийн комиссын ажлын албаны үйл ажиллагааны цөмийн салбарын бодлогын судалгаанд зориулан 2021 оны төсөвт “Эрдэм шинжилгээ, судалгаа”-ны 73,526.1 мянган төгрөгийн зардал тусгагдсан ба үүнээс 10 хувийг хэмнэн 2021 онд нийт санхүүжилтийн 90 хувь буюу 66,173.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Олон улсын байгууллага, гэрээ, конвенцын итгэмжит санд гишүүнчлэлийн татварт жил бүр 478,466.2 мянган төгрөгийг төсөвт суулган төлж, гэрээний хэрэгжилтийг дүгнэдэг байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд байгууллага нь хууль, тогтоол, журам заавар зөрчсөн асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төсөл боловсруулахдаа төсвийн байгууллагын үйл ажиллагаанаас орох орлогыг дээд шатны төсвийн захирагч төсвийн төслийг хянахдаа төсвийн дүнд оруулж баталдаггүй боловч үндсэн үйл ажиллагаанаас орох орлогыг төсөвт байгууллагын өөрийн орлого гэж тайлагнаж байна.

Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар АОУС 701.8-д тодорхойлсон санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөхүйц асуудлууд илрээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна. Энэхүү асуудлын хүрээнд аудитын горим сорилыг хэрэгжүүлж, зарим алдаатай асуудлыг илрүүлж, аудитын тайланд тусгав.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 нэр төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цөмийн энергийн комиссын Ажлын алба нь 2021 онд нийт 758,441.5 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 135 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, 2 мэдээллийн хугацаа болоогүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлж байх талаар албан шаардлага хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд хийсэн худалдан авах үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид бүрэн нийцсэн, худалдан авах ажиллагааныхаа сайтад мэдээлэл байршуулсан, үнэлгээний хорооны гишүүдийн бүрэлдэхүүн хууль журамд нийцсэн, "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ыг мөрдөж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн, шалгасан аудитын горим сорилын үр дүн нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалт, шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 79,567.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 29,915.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулах, хэрэгцээнээс илүү бэлтгэж 8 жил агуулахад хадгалагдаж байсан 8,136.6 мянган төгрөгийн бараа материалтай холбоотой асуудлыг цэгцлэх, хөрөнгийн ангилал буруу бүртгэж, тайлагнасан 28,995.1 мянган төгрөгийн алдааг залруулж, цаашид зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад дараах байдалтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,141.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 зөвлөмж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|---------|---------|---------|-------|-----|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | - | - | - | - | - | 100 |
| Зөвлөмж | 1 | 2,141.9 | 1 | 2,141.9 | - | - | 100 |
| Нийт дүн | 2 | 2,141.9 | 2 | 2,141.9 | - | - | 100 |

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрч байсан алдаа зөрчлийг давтахгүй байх, тайлант оны аудитаар зарим дансдын журналын тоо дүн давхар татагдаж байгаа нь санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, санхүүгийн мэдээлэл үнэн зөв ойлгомжтой бэлтгэгдэхэд хүндрэлтэй байдал үүсэхээр байна. Иймд нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг шинэчлэн сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 35,747.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 28,995.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,752.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 6,752.5 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 26,675.9 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын дансанд бүртгэлтэй 28,995.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг залруулж бүртгэсэн.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Бараа материалын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

2014-2020 онд бэлтгэсэн насжилт өндөртэй 1,467.0 мянган төгрөгийн бараа материал байгаа нь УСНББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн НББ-ийн тухай хуулийн 5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, ЗГ-ын 43 дугаар тогтоолын заалтад нийцэхгүй байгаа бөгөөд Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид хэрэгцээнээс илүү материал бэлтгэхгүй байх, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын заалтын дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай, аривлан хэмнэлттэй зарцуулах бодлого чиглэлийг баримтлан тодорхой арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг сар бүр тооцож ажиллах.

2. **Санхүүгийн программ хангамжтай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн программаас хөрөнгийн дансдын оны эхний үлдэгдэл, тайлант оны орлого, зарлагын дүн давхар татагдсан, санхүүгийн тайлангийн зарим үзүүлэлтүүд 5,285.5 мянган төгрөгийн алдаатай гарч байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжтай холбоотой алдаа дахин гаргахгүй болох тодорхой арга хэмжээг авч, үр дүнг тооцох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| 6 | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа, зөрчлийн товч утга | Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга | Нийт алдаа зөрчил | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---------------------------------|----------------------------|-------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|----------|-----------|----------|---------------|-----|-----------------|-----|---------|---------|
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | |
| 1 | Цөмийн энергийн аждын алба | АХГ-2022/152/НА-СТА-ТШЗ | Хөрөнгө буруу ангилан бүртгэж, тайлагнасан | 28,995.1 мянган төгрөгийн хөрөнгийг тусгай зориулалтын материалд бүртгэснийг залруулж үндсэн хөрөнгийн ангилалд бүртгэсэн. | 1 | 28,995.1 | 1 | 28,995.1 | | | | | | |
| | Цөмийн энергийн аждын алба | АХГ-2022/152/НА-СТА-ТШЗ | 2014-2020 онд бэлтгэсэн насжилт өндөртэй 1,467.0 мянган төгрөгийн бараа материал байна | Хэрэгцээнээс илүү бэлтгэсэн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэж ажиллах бодлого чиглэлийг баримталж ажиллах | 1 | 1,467.0 | | | | | | | 1 | 1,467.0 |
| | Цөмийн энергийн аждын алба | АХГ-2022/152/НА-СТА-ТШЗ | Хөрөнгийн дансдын оны эхний үлдэгдэл тайлант оны орлого, зарлагын дүн давхардаж татагдсан, санхүүгийн тайлангийн зарим үзүүлэлтүүд алдаатай татагдсан | Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг шинэчлэн сайжруулж, холбогдох стандарт, хууль, журам зааварт нийцсэн мэдээ, тайлан бэлтгэхэд анхаарах | 1 | 5,285.5 | | | | | | | 1 | 5,285.5 |
| | ДҮН | | | | 3 | 35,747.6 | 1 | 28,995.1 | | | | | 2 | 6,752.5 |

| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | |
|----------------------------------------------------------|--|-------------------------|----------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|---|--|--|--|--|--|---|--|--|
| 1 | | АХГ-2022/152/НА-СТА-ТШЗ | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 15 мэдээлэл хоцроосон | Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийг тус тус мөрдөж ажиллах; | 1 | | | | | | 1 | | |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 о. 4 дугаар сарын 25 № 295/А.0150458
АХГ-2022/152/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим мэдээллийн санд байршуулбал эсхих 151 мэдээллээс 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3 "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван зая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гэржүүлэхгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, хугацаанд нь байршуулж байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга Г. Манлайжав, нягтлан бодогч П. Номин Эрдэнэ нарт хариуцуулав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ОЛ ДӨШ ХАЙРХАН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Ц.БУМЦЭНД



Монгол Улсын Засгийн газар хэргийн үйлчилгээний газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Ногоо тойргийн-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-714230

МОНГОЛ УЛСЫН АУДИТЫН ГАЗАР

0010866885